



**МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 4/01

Улаанбаатар хот

2025 оны зорилт дэвшүүлэн
хэрэгжүүлэх тухай

“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилгыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, ирээдүйн хэрэгцээг тодорхойлох, түүнд хүрэхэд учирч болох эрсдэлийг тооцох, бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөц бий болгох, ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг төгөлдөршүүлэх, хөгжүүлэх ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2025 оныг “Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжих жил” болгон зарласугай.

2. Зорилтыг биелүүлэх ажлын төлөвлөгөө, төсвийг хамтран боловсруулж, батлуулахыг Хүний нөөцийн албаны дарга (С.Цэвээндорж), Техникийн бодлого, стандартчиллын албаны дарга (С.Мөнх-Алдар), Дотоод аудит, хяналт шалгалтын албаны дарга (Д.Ууганбаяр), Төлөвлөлт, эдийн засгийн албаны дарга (З.Энхбаяр), Замын даргын ажлын албаны дарга (С.Сумъяадорж) нарт даалгасугай.

3. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга (С.Цэвээндорж)-д, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг улирал бүр Замын удирдлагад танилцуулж ажиллахыг Техникийн бодлого, стандартчиллын албаны дарга (С.Мөнх-Алдар)-д үүрэг болгосугай.

4. Замын орлогч дарга нарт өөрсдийн хариуцсан чиглэлээр ажил зохион байгуулж, төлөвлөгөөний биелэлтийг хангуулах арга хэмжээ авахыг даалгасугай.

5. Бүх алба, хэлтэс, төв, тасаг, салбар нэгжээс нэмэлт мэдээлэл авах, төлөвлөгөөний гүйцэтгэлийг сайжруулах тухай зөвлөмж, шаардлага хүргүүлэх эрхийг Техникийн бодлого, стандартчиллын албаны дарга (С.Мөнх-Алдар)-д олгосугай.

6. Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжих ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр дүгнэж, гүйцэтгэлийг жилийн эцэст нэгтгэн гаргахыг Замын орлогч дарга нар, бүх алба, бие даасан хэлтэс, төв, тасаг, салбар нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

1601250001

7. “Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжих жил” зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг томилон ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга (С.Цэвээндорж), Техникийн бодлого, стандартчиллын албаны дарга (С.Мөнх-Алдар) нарт даалгасугай.

8. Батлагдсан төлөвлөгөөний дагуу зардлыг төлөвлөж санхүүжүүлэхийг Эдийн засаг, санхүү хариуцсан замын орлогч дарга бөгөөд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга (Усольцева С.Я.) -д даалгасугай.

9. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Удирдлагын асуудал хариуцсан замын орлогч дарга (М.Цогт)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН